

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОРИЛТЫН
БИЕЛЭЛТЭД 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО:

“Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны чиг үүргийн хүрээнд хийж гүйцэтгэхээр тусгагдсан зорилтын хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах зарим асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулан яам, холбогдох дээд байгууллагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангахад хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТҮВШИН ҮНЭЛСЭН БАЙДАЛ:

Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ыг үндэслэл болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12-р сарын 18-ний өдрийн 218 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны чиг үүргийн хүрээнд 4 бодлогын 82 зорилтын 121 арга хэмжээний хэрэгжилтийг 2025 онд хангуулж ажиллаж байна. Үүнээс үндсэн хэрэгжүүлэгч 61 арга хэмжээ, хамтран хэрэгжүүлэх 60 арга хэмжээ байна. Дээрх төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар үнэлгээ хийхэд 85 хувиас дээш буюу “үр дүнтэй” хэрэгжилттэй 64 арга хэмжээ, 60-84 хувийн буюу “үр дүн хүлээгдэж байгаа” хэрэгжилттэй 14 арга хэмжээ, 30-59 хувийн буюу “Үр дүн хангалтгүй” хэрэгжилттэй 13 арга хэмжээ, 0-29 хувийн буюу “үр дүн гараагүй” хэрэгжилттэй 27 арга хэмжээ, хугацаа болоогүй /ХБ/ 3 арга хэмжээ үнэлэгдэж, 2025 оны жилийн эцсийн байдлаар гүйцэтгэл “Үр дүн хүлээгдэж байгаа” буюу 67,4 хувьтай, өссөн дүнгээр 35,6 хувьтай үнэлэгдлээ.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг харуулбал:

Хүснэгт 1

№	Үзүүлэлт	Зори лт	Нийт арга хэмжээ	Үүнээс				ХБ	Тухайн жилийн дүн %	Өссөн дүн %
				85 хувиас дээш	60-84 хувьтай	30-59 хувьтай	0-29 хувьтай			
1	Үндсэн хэрэгжүүлэгч арга хэмжээ	40	61	32	13	4	12	-	69,83	38.81
2	Хамтран хэрэгжүүлэгч арга хэмжээ	42	60	32	1	9	15	3	63.51	33.25
Нийт дүн		82	121	64	14	13	27	3	67.4	35.6

Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:

Хүснэгт-1.1



№	Бодлого																							
	1			1			2			2			3			3			4					
	Бүсчилсэн хөгжлийн бодлого	Тухайн жилийн гүйцэтгэл хувь	Өссөн дүн %	Бүсчилсэн хөгжлийн бодлого	Тухайн жилийн гүйцэтгэл хувь	Өссөн дүн %	Хүний хөгжлийн бодлого	Тухайн жилийн гүйцэтгэл хувь	Өссөн дүн %	Хүний хөгжлийн бодлого	Тухайн жилийн гүйцэтгэл хувь	Өссөн дүн %	Эдийн засгийн бодлого	Тухайн жилийн гүйцэтгэл хувь	Өссөн дүн %	Эдийн засгийн бодлого	Тухайн жилийн гүйцэтгэл хувь	Өссөн дүн %	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	Тухайн жилийн гүйцэтгэл хувь	Өссөн дүн %			
1	1.1.1.1.1	50	50	1.2.1.1.71	100	100	2.1.1.24.206	10	0	2.4.2.1.445	80	40	3.1.3.8.496	30	0	3.4.1.7.970	100	100	4.2.3.9.1153	100	33.3			
2	1.1.1.1.2	30	30	1.2.1.2.75	100	10.5	2.1.1.24.207	100	25	2.4.2.2.446	0	0	3.2.2.11.540	100	5	3.4.2.1.971	100	5	4.2.4.3.1169	50	50			
3	1.1.1.1.3	30	30	1.2.1.2.76	0	0	2.1.1.35.224	60	30	2.4.2.3.447	100	50	3.2.2.12.542	100	5	3.4.2.1.972	100	50	4.2.4.3.1170	100	22.2			
4	1.1.1.2.5	100	100	1.2.1.2.78	100	100	2.1.3.1.251	100	100	2.4.2.4.449	60	23.1	3.2.2.12.547	100	30	3.4.2.2.974	100	100						
5	1.1.3.2.29	0	0	1.2.1.3.79	0	20	2.2.1.7.316	100	100	2.4.2.5.450	100	100	3.3.1.6.577	0	0	3.4.3.3.1000	100	0						
6	1.1.3.2.30	100	71.8	1.2.1.3.80	0	10	2.2.1.7.319	100	100	2.4.2.5.451	100	100	3.3.1.6.578	ХБ	ХБ	3.4.3.4.1001	100	41.7						
7	1.1.3.4.31	0	0	1.2.1.3.81	100	20	2.2.3.3.369	100	10	2.4.2.6.452	100	100	3.3.3.3.705	0	0	3.4.3.4.1002	100	96.3						
8	1.1.3.4.32	100	15	1.2.1.3.82	0	5	2.3.2.1.402	100	100	2.4.2.8.454	100	25	3.3.3.19.730	80	40	3.4.3.4.1003	100	40						
9	1.1.3.4.33	0	0	1.2.2.1.84	50	50	2.3.2.1.404	100	5	2.4.2.8.455	0	0	3.3.3.38.756	50	50	3.4.3.4.1004	100	0						
10	1.1.3.4.34	0	0	1.2.2.2.85	100	31.3	2.3.2.1.405	100	5	2.4.3.1.456	71.4	50	3.3.4.35.873	100	100	3.4.3.5.1005	0	0						
11	1.1.3.4.35	75	21.4	1.2.2.3.86	0	0	2.4.1.1.433	60	30	2.4.3.2.457	100	30	3.3.5.7.889	0	0	3.4.3.5.1006	0	0						
12	1.1.3.5.36	30	30	1.2.2.3.87	0	0	2.4.1.2.435	98.2	22.7	2.4.3.2.458	100	30	3.3.5.8.890	100	100	3.4.3.7.1009	100	100						
13	1.1.3.6.38	ХБ	ХБ	2.4.1.2.436	0	0	2.4.1.2.436	66.7	20	2.4.3.3.459	33.3	10	3.3.5.9.892	0	0	3.4.3.7.1010	100	100						
14	1.1.3.7.39	100	25	1.3.1.1.96	83.3	55.6	2.4.1.2.437	67.6	16.9	2.4.3.4.460	20	10	3.3.6.3.904	30	0	3.4.3.7.1011	100	5						
15	1.1.3.7.40	70	20	1.3.1.2.97	100	100	2.4.1.4.439	100	100	2.4.3.4.461	100	97.8	3.3.6.5.912	ХБ	ХБ	3.4.3.7.1012	53.3	8.42						
16	1.1.3.7.41	100	100	1.3.5.4.131	50	0	2.4.1.4.440	0	0	2.4.3.4.462	84.2	84.2	3.3.6.7.915	100	10	3.4.3.10.1018	0	0						
17	1.1.3.8.42	100	40	1.3.5.4.132	50	0	2.4.1.6.442	100	50	2.4.3.4.463	90.8	90.8	3.4.1.7.968	90	90	3.4.3.10.1019	100	30						
18	1.1.4.1.43	75	21.4	1.4.1.5.144	93.3	31.1	2.4.1.7.443	0	0	2.4.3.4.464	93.3	28				3.4.3.10.1020	100	0						
19	1.1.4.6.55	100	100	1.4.1.6.145	100	50	2.4.1.8.444	100	41.1	2.4.3.7.468	100	15												
20	1.1.4.7.58	100	5	1.4.1.8.147	0	0																		
21	1.1.5.3.63	100	5	1.4.1.8.148	100	30																		
22	1.1.5.3.66	100	0	1.4.2.6.160	0	0																		
23	1.2.1.1.70	83.3	71.4																					
					58.4	30.7						76.2	43.1					67.7	33.5			83.3	35.2	

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 2025 оны жилийн эцсийн байдлаар 30-59 хувийн буюу “Үр дүн хангалтгүй” хэрэгжилттэй 13 арга хэмжээ, 0-29 хувийн буюу “үр дүн гараагүй” хэрэгжилттэй 27 арга хэмжээ, нийт 40 арга хэмжээ байна.

Хэрэгжилт 30-59 хувийн буюу “Үр дүн хангалтгүй” биелэлттэй дараах 13 ажил байна. Үүнд:

- 1.1.1.1.2. "Агро-сити", "Налуу-Ухаа" эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах.
- 1.1.1.1.3. "Агро-сити", "Шарга морьт" дагуул хотуудын эдэлбэр газрын хэмжээ, заагийг батлуулж, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах.
- 1.1.1.2.5. Орон сууцны хорооллуудад хот байгуулалт, барилгын хяналтыг хэрэгжүүлж, төлөвлөлтийг норм, стандартад нийцүүлэх ажлыг зохион байгуулах.
- 1.1.3.4.36. Гэр хороолол, дэд төв, дагуул хотуудад орон сууц барих аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлэх
- 1.2.2.1.84. Номтын аманд эрчим хүчний хэмнэлттэй төр захиргааны нэгдсэн байрыг барьж байгуулах.
- 1.3.5.4.131.Хөшигийн хөндийн чөлөөт бүсэд барилгын материалын хангамжийн төв байгуулах
- 1.3.5.4.132. "Алтанбулаг" чөлөөт бүсэд барилгын материалын хангамжийн төв байгуулах.
- 2.4.3.3.459. Ус хангамж, ариутгах татуурга, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.
- 3.1.3.8.496. Ногоон орон сууцны санхүүжилтийн хөрөнгө оруулалтын сан байгуулах.
- 3.3.3.38.756. Нийгэм, ахуйн барилгын цахилгаан байгууламжийн техник ашиглалтын дүрэм, стандартыг сайжруулах.

11. 3.3.6.3.904. Музей шинээр барьж ашиглалтад оруулах.
12. 3.4.3.5.1012. Тогтвортой, ухаалаг хотын үзүүлэлтийн батлагдсан стандартыг нэвтрүүлэх
13. 4.2.4.3.1169. Хот байгуулалтын тухай болон Барилгын тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Хэрэгжилт 0-29 хувийн буюу “үр дүн гараагүй” биелэлттэй дараах 27 ажил байна. Үүнд:

1. 1.1.3.2.29. Зөөврийн бохир усанд урьдчилсан цэвэрлэгээ хийх зориулалт бүхий бохир усны юүлэх станцыг барьж байгуулах.
2. 1.1.3.4.31. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, холбогдох дүрэм, журмыг шинэчлэх.
3. 1.1.3.4.33. Нийслэлийн гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд гадна инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлыг эрчимжүүлэх
4. 1.1.3.4.34. Нийслэлийн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх.
5. 1.2.1.2.76. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ барих төслийг хэрэгжүүлэх.
6. 1.2.1.3.79. Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барих.
7. 1.2.1.3.80. Багахангайн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг барих.
8. 1.2.1.3.82. Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийг барих.
9. 1.2.2.3.86. Булагтай, Нарийн нуур хэсгийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх.
10. 1.2.2.3.87. Баялаг хороололд 6/0,4кВ-ийн 2х400кВа чадалтай цахилгааны дэд өртөөний станц барих.
11. 1.2.2.3.88. Цэвэр усны станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх.
12. 1.4.1.8.147. Орхон аймгийн төв Эрдэнэт хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж, батлуулах.
13. 1.4.2.6.160. Хот, суурин газруудын хүн амын ундны цэвэр усны шугамыг зэс шугамаар солих судалгаа хийж, загвар төсөл хэрэгжүүлэх.
14. 2.1.1.24.206. Барилга байгууламжийн дэд бүтцийг сайжруулах чиглэлээр хүртээмжийн үнэлгээ зохион байгуулах.
15. 2.4.1.4.440. "Солонго 1, 2" 5002 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэх.
16. 2.4.1.7.443. "Миний амины орон сууц" хөтөлбөрийн хүрээнд гэр хорооллын иргэдэд эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барьсан тохиолдолд 30 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх.
17. 2.4.2.2.446. Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууц барих, худалдан авахад ипотекийн зээл олгох журмыг шинэчлэх.
18. 2.4.2.2.8.455. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх олгох чиг үүргийг мэргэжлийн холбоонд шилжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.
19. 2.4.3.4.460. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу ус хангамж, ариутгах татуургын инженерийн шугам сүлжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх.
20. 3.3.1.6.577. Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх.
21. 3.3.3.3.705. Нийгмийн үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламжийг пассив барилгын стандартад нийцүүлэхэд шаардлагатай норм,

нормативын баримт бичгийн судалгаа хийж, шаардлагатай норм, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах.

22. 3.3.5.7.889. Гол бүс нутгуудад аялал жуулчлалын цогцолбор байгуулах.

23. 3.3.5.9.892. Бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан үндэсний агуулгатай дизайн архитектур бүхий соёлын орон зайг нэмэгдүүлэх.

24. 3.4.3.4.1004. "Морингийн давааны цэвэрлэх байгууламжийг өргөтгөх төсөл"-ийг хэрэгжүүлэх.

25. 3.4.3.5. 1005.Цэвэрлэх байгууламжийн 1000 м3 лагийг бордоо болгож уул уурхайн нөхөн сэргээлтэд ашиглах туршилтын төсөл хэрэгжүүлэх.

26. 3.4.3.5.1006. Гэр хорооллын 500 өрхийн ариун цэврийн байгууламжийн лагийг багасгах, үнэргүйжүүлэх, цэвэрлэх аргаар хөрсийг эрүүлжүүлэх туршилтын төсөл хэрэгжүүлэх.

27. 3.4.3.10. 1018. Монгол орны онцлогт тохирсон, эрчим хүч, ус, бохирын хувьд бие даасан, байгальд ээлтэй, зөөврийн орон сууцны технологийн судалгааг хийх.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ:

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12-р сарын 18-ний өдрийн 218 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгагдсан 121 арга хэмжээний биелэлтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд “Үр дүн хүлээгдэж байгаа” буюу 67,4 хувьтай, өссөн дүнгээр 35,6 хувьтай үнэлэгдлээ.

1. Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний барилга байгууламж, төсөл хөтөлбөрүүдийн арга хэмжээнүүдийн гүйцэтгэл тодорхой түвшинд хүрсэн боловч шалгуур үзүүлэлт нь оновчтой бус /тоогоор илэрхийлсэн/ илэрхийлэгдсэн тул хэрэгжилтийн биелэлт хангалтгүй буюу 0 гарах магадлал өндөр байна.

2. Арга хэмжээнүүдийн шалгуур үзүүлэлтүүд (суурь түвшинтэй)- ийг зарим арга хэмжээнд өссөн дүнгээр, зарим арга хэмжээнд тайлант хугацаагаар төлөвлөсөн нь үнэлэхэд хүндрэлтэй байна.

3. Арга хэмжээнүүдийн хамтран хэрэгжүүлэх байгууллага нь тухайн арга хэмжээнүүдийн хүрээнд ямар ажил хийх шалгуур үзүүлэлт, хамрах хүрээний хязгаарлалт байхгүй, тодорхойгүй байгаа нь биелэлт бичих, үнэлгээ өгөх боломжгүй байна.

ТАВ: САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Засгийн газрын үйл ажиллагааны 2024-2028 оны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд хяналт шинжилгээ хийж хэрэгжилт, бодлогын баримт бичгийн хоорондын уялдааг сайжруулах, бодлого, төлөвлөлтийн бичиг баримтад өөрчлөлт оруулах саналуудын талаар дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 2025 оны жилийн эцэс байдлаар 30-59 хувийн буюу “Үр дүн хангалтгүй” хэрэгжилттэй 13 арга хэмжээ, 0-29 хувийн буюу “үр дүн гараагүй” хэрэгжилттэй 27 арга хэмжээ, хугацаа болоогүй 1.1.3.6. 38. Бохир усны Туул-1 коллекторыг дуусгаж ашиглалтад оруулах, 3.3.1.6.578. Газрын тос дамжуулах

хоолойн барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах, 3.3.6.5.912. Соёлын биет бус өвийн үндэсний төвийг байгуулж, барилгыг ашиглалтад оруулах 3 арга хэмжээ, нийт 40 арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлэх талаар 2026 онд төлөвлөгөө гарган ажиллахыг бүх газар, хэлтсүүдэд үүрэг болгож, хэрэгжилтийг хангах;

2. Тодорхой түвшний гүйцэтгэл бүхий барилга байгууламж, төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж буй арга хэмжээнүүдийн шалгуур үзүүлэлтүүд нь оновчтой бус тоогоор илэрхийлэгдсэнээс хэрэгжилтийн биелэлт хангалтгүй буюу 0 гарах магадлалтай, мөн шалгуур үзүүлэлтийн тоон үзүүлэлтийг өссөн дүнгээр илэрхийлээгүй дараах арга хэмжээнүүдийн шалгуур үзүүлэлтүүдэд өөрчлөлт оруулах. (арга хэмжээний дугаараар дугаарласан). Үүнд:

- а. Эрх зүйн баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг тоогоор илэрхийлсэн 31, 147, 148, 446, 447, 705,
- б. Шалгуур үзүүлэлтийг өссөн дүнгээр тооцоогүй 30, 207
- с. Барилгын ажлыг тоогоор илэрхийлсэн 144, 439, 440, 1001, 1170;

3. Арга хэмжээнүүдийн хамтран хэрэгжүүлэх байгууллага нь тухайн арга хэмжээнүүдийн хүрээнд ямар ажил хийх шалгуур үзүүлэлт, хамрах хүрээний хязгаарлалт байхгүй, тодорхойгүй байгаа тул хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан 60 арга хэмжээнд яамны оролцоог тодорхой болгож батлуулах, оролцоогүй ажлуудыг хасуулах саналаа гарган хүргүүлэх;

4. Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагын хүрээнд хэрэгжиж байгаа 61 арга хэмжээ /арга хэмжээний дугаар/-ний 30, 39, 85, 435, 436, 437, 441, 444, 446, 1154 дэх, нийт 10 арга хэмжээ нь ипотекийн зээл, түүний журмын шинэчлэлтэй холбоотой байгаад судалгаа хийж багцлах;

5. Төсөл арга хэмжээнүүдийн биелэлтийг журмын “4.4.6.бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээ, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтааж, үг, үсгийн болон утга агуулгын алдаагүй тайлагнах”, “5.2.Хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгж, ажилтан (баг) нь бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд энэ журмын 6.1, 6.3, 6.4-т заасан аргачлалаар хяналт-шинжилгээ хийж, тайланг баталсан загварын дагуу гаргаж, нотлох баримтын хамт (байгууллагын удирдлагын зөвлөлийн шийдвэр болон бусад) энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд нэгдсэн системд тайлагнаж, баталгаажуулна” гэж заасны дагуу биелэлтийг гарган, нотлох баримтыг хавсарган, тухайн тайлант хугацаанд зарцуулсан хөрөнгийг тусган тайлагнахыг газар, нэгжүүдэд үүрэг болгох;

6. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43, дугаар тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 7.1.Хяналт-шинжилгээний дүнгээр хэрэгжиж байгаа бодлогын баримт бичиг “үр дүн гараагүй” болон “үр дүн хангалтгүй” үнэлэгдсэн тохиолдолд бодлого хэрэгжүүлэгч нь хяналт-шинжилгээний дүгнэлт, зөвлөмжид үндэслэн дараах арга хэмжээнээс аль тохирохыг авч хэрэгжүүлнэ гэж заасны дагуу 2, 3, 4 дүгээр зөвлөмжөөр өгсөн арга хэмжээнүүдэд тодотгол хийж, саналыг журмын “7.2.Байгууллагууд тайлант жилийн хяналт-шинжилгээний дүнг цахим системд тайлагнасан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор энэ журмын 7.1.3, 7.1.4-т заасан саналыг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэсэн хугацаанд хүргүүлэх, зөвлөмжийн биелэлтийг 10-р сарын 01-ний дотор ирүүлж ажиллахыг

холбогдох газруудтай хамтран хэрэгжүүлэхийг Хот байгуулалт, орон сууцжуулалтын бодлого зохицуулалтын газар /О.Одбаяр/-т даалгасугай.

7. Дээрх зөвлөмжийн биелэлтийг хангуулах ажлыг удирдан зохион байгуулж, үүрэгжүүлж ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баяраа/-д зөвлөж байна.

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ,
САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОНСУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ,
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР



ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОРИЛТЫН
БИЕЛЭЛТЭД 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР
ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**



ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ
